



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/16

Баян-Өндөр сум

Самбо бөхийн улсын аварга
шалгаруулах тэмцээнд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Самбо бөхийн 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), спортын холбоод, клубуудын асуудал, сургалт, дасгалжуулалт хариуцсан мэргэжилтэн (О.Мөнхзул) нарт үүрэг болгосугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 315,000 (гурван зуун арван таван мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн
10/16 дугаар тушаалын хавсралт

САМБО БӨХИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Өдөр	Хүний тоо	Шагналын дүн	Бүгд дүн (төгрөгөөр)
1	Хоолны зардал	3 өдөр	7	15,000	315,000
	Төсвийн нийт дүн				315,000

----oOo----